



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (171)

*Монгол Улсын хууль:*

- Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

*Монгол Улсын Их Хурлын тогтоол:*

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны есдүгээр сарын 12

№ 34 (171)

## Гарчиг

### Нэг. Монгол Улсын хууль

- |   |     |
|---|-----|
| 370. Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2000-8-31-ний хууль/                                | 636 |
| 371. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2000-8-31-ний хууль/ | 637 |
| 372. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2000-8-31-ний хууль/  | 640 |
| 373. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/   | 640 |
| 374. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/   | 640 |
| 375. Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/  | 641 |
| 376. Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/  | 641 |
| 377. Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/   | 641 |
| 378. Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/  | 642 |
| 379. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/   | 642 |
| 380. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/   | 642 |
| 381. Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2000-9-1-ний хууль/  | 642 |

### Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

- |  |           |     |
|--|-----------|-----|
| 382. Саналын хуудасны загвар батлах тухай  | Дугаар 27 | 643 |
| 383. Үнэт цаасны хорооны дарга, зарим гишүүнийг чөлөөлөх тухай                                       | Дугаар 28 | 643 |
| 384. Үнэт цаасны хорооны дарга, зарим гишүүнийг томилгох тухай                                       | Дугаар 29 | 643 |
| 385. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль төвлөн зарлах тухай | Дугаар 30 | 644 |

386. Сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай	Дугаар 31	644
387. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай	Дугаар 32	644
388. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	Дугаар 33	646
389. 2000 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 34	662

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН 2000 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 2000 төсвийн орлогын нийт дүн, нэр төрлийн оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 1 хэмжээнд дор дурдсан өөрчлөлт оруулсугай:  
дүгээр зүйлд заасан улсын төвлөрсөн

	мянган төгрөг/
<b>1.1.ОРЛОГО-БҮГД</b>	<b>8,019,821.9</b>
<b>1.1.1.Албан татварын орлого</b>	<b>3,533,793.6</b>
1.1.1.а.орлогын албан татвар	6,123,851.7
1.1.1.б.нэмэгдсэн өртгийн албан татвар	-1,858,985.6
1.1.1.в.онцгой албан татвар	-3,804,673.0
1.1.1.д.гаалийн албан татвар	3,067,250.0
1.1.1.ж.нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	6,350.5
<b>1.1.2.Татварын бус орлого</b>	<b>4,486,028.3</b>
1.1.2.а.хувьцааны ногдол ашиг	4,491,028.3
1.1.2.д.төсөвт байгууллагын өөрийн орлого	-5,000.0

2 дугаар зүйл. Монгол Улсын 2000 хамгаалах арга хэмжээний зардал, оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 2 төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, дугаар зүйлд заасан улсын төвлөрсөн тэтгэврийн даатгалын сан болон аймгийн төсвийн 2000 оны зарлагын нийт дүн, үүний төсөвт өгөх татаасын хэмжээнд дор дурдсан дотор цалин, хөрөнгө оруулалт, нийтийн өөрчлөлт оруулсугай:  
ерөнхий үйлчилгээний зардал, батлан

<b>2.1.ЗАРЛАГА-БҮГД</b>	<b>-1,759,116.1</b>
2.1.1.цалингийн сан	39,273.0
2.1.2.хөрөнгө оруулалт	
Үүнээс: -шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт өртөг	2,402,400.0
Үүний дотор: 2000 онд санхүүжүүлэх хэмжээ	-1,262,800.0
2.1.3.нийтийн ерөнхий үйлчилгээний зардал	-58,830.2
2.1.4.батлан хамгаалах арга хэмжээний зардал	338,161.9
2.1.5.Улсын Их Хурлын төсөв	227,500.0
2.1.10.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв	18,000.0
2.1.14.Улсын аюулгүй байдлыг хангах газрын төсөв	21,856.8
2.1.15.тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	-4,213.5
2.1.16.аймгийн төсөвт өгөх татаас	2,311,694.0

3 дугаар зүйл. Монгол Улсын 2000 өвөс аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээнд оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 3 дор дурдсан өөрчлөлт оруулсугай:  
дугаар зүйлд заасан улсын төвлөрсөн төс-

Архангай	43,955.8
Баян-Өлгий	41,400.2
Баянхонгор	78,304.2
Булган	174,196.4
Говь-Алтай	71,319.2

Дорноговь	66,069.7
Дорнод	53,956.7
Дундговь	123,396.8
Завхан	65,206.8
Өвөрхангай	100,388.8
Өмнөговь	58,200.4
Сүхбаатар	74,232.5
Сэлэнгэ	773,482.4
Төв	246,792.0
Увс	90,875.8
Ховд	59,919.0
Хөвсгөл	52,409.5
Хэнтий	63,925.1
Дархан-Уул	14,757.2
Улаанбаатар	24,238.2
Орхон	20,362.3
Говь-Сүмбэр	14,305.0

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн "аймгийн" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж өөрчилсүгэй.

8 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 8 дугаар сарын 31-ний өдөр**

**Улаанбаатар хот**

### АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 10, 16 дугаар зүйлийн 3, 21 дүгээр зүйлийн 3, 23 дугаар зүйлийн 6, 7, 36 дугаар зүйлийн 12, 13 дахь хэсэг, 5<sup>1</sup> дүгээр зүйл, 18<sup>1</sup> дүгээр зүйлийг тус тус нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/ сонгуулийн хорооны гишүүн тус хороонд ажилласан хугацааны хөлс, сонгуулийн хорооны бүрэлдэхүүний сонгуулийн едрийн хоолны зардал;"

2/ 9 дүгээр зүйлийн 4 хэсгийн 10 дахь заалт:

"10/ энэ хуулийн 23 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон, мөн зүйлийн 5, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмыг зөрчсөн нэр дэвшигчийг нэр дэвшигчдийн жагсаалтаас хасах;"

3/ 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангана:

1/ банкны зээл, түүний батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй;

2/ял шийтгэлгүй."

4/ 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Саналын хуудас хэвлэгдсэнээс хойш нэр дэвшигч нэрээ татахыг хориглоно."

5/ 23 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

"6.Нэр дэвшигч, түүний шадар туслагч, ухуулагч, нам, эвсэл, талархан дэмжигч этгээд санал худалдаж авах, сонгогчдыг татах зорилгоор тэдэнд төлбөртэй болон үнэ төлбөргүйгээр бараа тараах, шагнал, урамшуулал, тусламж олгох, дайллага хийх, урлаг, спорт, ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сонгуульд үл хамаарах ажил, үйлчилгээ явуулахыг хориглоно."

7.Нэр дэвшигч, түүний шадар туслагч, ухуулагч, бусад этгээд нь сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх буюу сонгуулийн хороо, түүний гишүүнээс үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад хийх, сонгуульд оролцохоос татгалзахыг нийтэд уриалах, сүсэг бишрэлийг далимдуулах, санал тоолох ажлыг зориуд саатуулах, сонгогч бусдын нэрийн өмнөөс сонгуульд оролцохыг хориглоно."



6/ 36 дугаар зүйлийн 12,13 дахь хэсэг:

"12. Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмыг зөрчсөн этгээд саналын хуудсыг дахин хэвлэхэд гарах зардлыг бүрэн хариуцна.

13. Сонгогдсон иргэдийн Төлөөлөгч-дийн Хурлын төлөөлөгч сонгуулийн хугацаанд энэ хуулийн 23 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг

болон бусад хууль тогтоомж зөрчсөн, банкны зээл, түүний батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өртэй, мөн ял шийтгэлтэй нь нотлогдсон бол тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний төлөөлөгчийн бүрэн эрхийг зогсооно."

7/ 5<sup>1</sup> дүгээр зүйл:

### " 5<sup>1</sup> дүгээр зүйл. Сонгуулийн тойрог, түүнийг байгуулах

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгоход хүн амын тоог харгалзан тойрог бүр нэг мандаттай байхаар тооцож тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 18-аас доошгүй хоногийн өмнө сонгуулийн тойрог байгуулна.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар тогтооно."

8/ 18<sup>1</sup> дүгээр зүйл:

### "18<sup>1</sup> дүгээр зүйл. Нэр дэвшигч барьцаа өгөх

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигч бүр 10000, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигч бүр 5000 төгрөгийг аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн сонгуулийн хороонд барьцаа болгон өгнө.

2. Нам, эвслээс нэр дэвшигчийн барь-

цааны мөнгийг тухайн нам, эвсэл нь, харин бие даан нэр дэвшигч барьцааны мөнгөө өөрөө хариуцна.

3. Нэр дэвшигч нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдвол барьцааг эгүүлэн олгоно. Барьцааны үлдсэн мөнгийг орон нутгийн төсөвт оруулна."

### 2 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум,

дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 хэсгийн 2-т "удирдах" гэсний дараа ", шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянах"; 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "жагсаалтыг сонгуулийн" гэсний дараа "тойрог,"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "иргэний" гэсний дараа "үнэмлэх,"; 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бүртгэгдсэн" гэсний дараа "тухайн"; мөн зүйлийн 3 дахь хэсгийн "тухайн" гэсний дараа "тойрогт сонгогдох"; 28 дугаар зүйлийн 3,4 дэх хэсгийн "иргэний" гэсний дараа "үнэмлэх,"; мөн зүйлийн 5 дахь хэсэгт "Эсхүл тусгайлан тэмдэг тавьж болно,"; 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "тухайн" болон "тоог сонгуулийн" гэсний дараа "тойрог," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2, 27 дугаар зүйлийн 3,4; 29 дүгээр зүйлийн 3, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт; 35 дугаар зүйлийн 1, 2; 36 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсгийг тус тус дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Нам, эвслийн тухайн шатны засаг захиргааны нэгжийн салбар байгууллага нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд тойрог тус бүрийн мандатын тоогоор нэр дэвшүүлнэ."

2/ 27 дугаар зүйлийн 3,4 дэх хэсэг:

"3. Саналын хуудсыг аймаг, нийслэл, сум, дүүргээр тус тусад нь хэвлэнэ.

4. Саналын хуудсанд дугаар, нэр дэвшигчдийн овог, нэр нам, эвслийн харьяаллыг бичнэ. Нэр дэвшигчдийн дарааллыг нэр дэвшүүлсэн нам, эвслийн Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар тогтооно. Эвслийг дараалалд оруулахдаа эвсэлд оролцогч намуудаас хамгийн түрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын дарааллаар тогтооно."

3/ 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Сонгогч саналын хуудсыг авч санал бэлтгэх тасалгаанд орж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас тус бүр нэг нэр дэвшигчийн өмнөх дугаарыг дугуйлан тэмдэглээд саналын хайрцагт хийнэ."



4/ 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/ энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийсэн нь аль нэгэн нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн нь тодорхойгүй бол."

5/ 35 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг:

"1.Сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, чөлөөлөгдсөн, шилжсэн, бүрэн эрх нь зогсоогдсон бол тухайн тойрогт нөхөн сонгууль явуулна.

2. Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын бүрэн эрхийн хугацаа нь нэг жил хүрэхгүй бол нөхөн сонгууль явуулахгүй."

6/ 36 дугаар зүйлийн 3,5 дахь хэсэг:

"3. Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн бол 50000 хүртэл төгрөгөөр торгоно.

5.Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг зөрчсөн иргэнийг 40000-50000, нам, эвсэл, талархан дэмжигч этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгоно."

**4 дүгээр зүйл.** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "3" гэсэн дугаарыг "4" ; 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "30-аас" гэснийг "21-ээс" ; 6 дугаар зүйлийн "25-аас" гэснийг "16-аас" , 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "25-аас" гэснийг "18-аас"; мөн зүйлийн 4 дэх хэсгийн "10" гэсэн дугаарыг "11"; 10 дугаар зүйл болон 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "20-иос" гэснийг "16-аас"; 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "гуравны хоёроос доошгүй" гэснийг "олонхи"; 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "12-оос" гэснийг "8-аас"; 15 дугаар зүйлийн "санал авах өдрөөс" гэснийг "саналын хуудас хэсгийн хороонд очихоос"; 16 дугаар зүйлийн гарчгийг " Нэр дэвшүүлэх хугацаа, нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлага"; мөн зүйлийн 1 дэх хэсгийн "7" гэснийг "4"; "10" гэснийг "5"; 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн " хуулиар тогтоосон" гэснийг "мандатын"; 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "17" гэснийг "13"; 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "15-аас" гэснийг "10-аас"; 22 дугаар зүйлийн "12" гэснийг "10"; 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "10-аас" гэснийг "6-аас", 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "сум, дүүрэг, баг, хороо" гэснийг "тойрог"; мөн зүйлийн 3 дахь хэсгийн "сум, дүүрэг, баг, хороонд" гэснийг "тойрогт"; 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-ийн "1, 3 дахь" гэснийг "1 дэх"; "30" гэснийг"14"; мөн хэсгийн 2-ийн "25-аас" гэснийг "12-оос", "20-иос" гэснийг "10-аас"; мөн хэсгийн 3-ийн "7" гэснийг"4", "10" гэснийг "3"; мөн хэсгийн 4-ийн

"15" гэснийг "10", "10-аас" гэснийг "5-аас"; 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "50000 хүртэл" гэснийг "40000-60000"; мөн зүйлийн 6 дахь хэсгийн "гэм буруутай албан тушаалтан" гэснийг " гэм буруутай албан тушаалтанг 40000-60000"; мөн зүйлийн 7 дахь хэсгийн "10000" гэснийг "60000" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "хорооны гишүүний тус хороонд ажилласан хөлс, сонгуулийн"; мөн хэсгийн "3"; 9,10,11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "нам, эвсэл"; 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө"; 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх төлөөлөгчид"; 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "нам, эвсэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс нэр дэвшигч, бие даан"; 32 дугаар зүйлийн 1 хэсгийн "болон нам, эвслийн төлөө өгсөн саналын тоог аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс буюу бие даан" гэснийг; мөн зүйлийн 3 дахь хэсгийн "нам, эвслээс буюу бие даан"; мөн хэсгийн "сум, дүүрэг, баг, хороог төлөөлөн"; мөн зүйлийн 8 дахь хэсгийн "нам, эвсэл болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс буюу бие даан"; 36 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн сүүлчийн өгүүлбэрийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5 дахь заалт, 2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 4-7, 35 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУльд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь тухайн аймаг, нийслэл, суманд байнга оршин суугч байна. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь тухайн дүүрэгт байнга оршин суугч, эсхүл тухайн дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгжид ажил, хөдөлмөр эрхэлдэг байна."

**2 дугаар зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 12<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргыг сонгохдоо төлөөлөгч-

дийн дотроос нэр дэвшүүлэн хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар сонгоно."

**3 дугаар зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй" гэснийг "нийт төлөөлөгчдийн олонхи"; мөн зүйлийн 7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг " Хуралдааныг багт 5 өрх, 50-иас дээш мянган хүн амтай сумын багт 10, хороонд 15 өрх тутмаас сонгуулийн насны тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно." гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУльд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9-д Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх ажлын хүрээнд "стандарт, хэмжил зүйн асуудал" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9-д Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх ажлын хүрээний "гадаадын худалданы бодлого, зохицуулалт" гэснийг "гадаад худалдааны болон гадаадын хөрөнгө оруулалтын бодлого;" гэж өөрчлөн найруулсугай.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-д Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх ажлын хүрээнд "гадаадын хөрөнгө оруулалтын бодлого;" "стандарт, хэмжил зүйн асуудал;" гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 53 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:**

"4/ ашигт малтмалын тухай хууль тогтоомжид хяналт тавих үүрэг бүхий агентлагийг байгуулж ажиллуулах;"

**2/ 53 дугаар зүйл:**

"53 дугаар зүйл. Геологи, уул уурхайн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих улсын хяналт

Хайгуул хийх, ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутагт хяналтын албад эрхлэн зохион байгуулж хэрэгжүүлнэ."

**2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Геологи, уул уурхайн хяналтын албанд" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагад", 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 10 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "Геологи, уул уурхайн хяналтын алба" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага", 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Геологи, уул уурхайн хяналтын албанаас" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагаас", 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Геологи, уул уурхайн хяналтын албаны" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагын" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авто замын тухай хуулийн 7.1 дэх хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Барилгын тухай хуулийн 18.1 дэх хэсгийн "барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагад" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 8.2 дахь хэсгийн "геодези, зураг зүйн төрийн захиргааны байгууллагад" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллагад" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

**2 дугаар зүйл.** Геодези зураг зүйн тухай хуулийн 5.4.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "эрчим хүчний улсын хяналтын байгууллага" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "харилцаа холбооны улсын хяналтын алба" гэснийг "мэргэжлийн хяналтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

**9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 46.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"46.1. Эрүүл мэндийн мэргэжлийн хяналтыг эрүүл мэндийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтаар хэрэгжүүлнэ."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

### СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

"3. Соёлын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг соёлын хяналтын асуудал эрхэлсэн мэргэжлийн хяналтын улсын алба хэрэгжүүлнэ."

**2 дугаар зүйл.** Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Саналын хуудасны загвар батлах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн саналын хуудсыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

*Улсын Их Хурлын 2000 оны 27 дугаар тогтоолын хавсралт*

### САНАЛЫН ХУУДАС

..... ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ..... ДУГААР ТОЙРОГ

(Та өөрийн сонгохыг хүссэн зөвхөн нэг нэр дэвшигчийн овог, нэрийн өмнөх дугаарыг дугуйлна уу!)

Хэсгийн хорооны дарга..... ТЭМДЭГ  
Нарийн бичгийн дарга.....

Д/д	Овог, НЭР	Нэр дэвшүүлсэн субъектын нэр
1		
2		
3		
4		

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Үнэт цаасны хорооны дарга, зарим гишүүнийг чөлөөлөх тухай

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Жигжидсүрэнгийн Ядамсүрэнг Үнэт цаасны хорооны даргын үүрэгт ажлаас, Долгормаагийн Буянтгогтохыг Үнэт цаасны хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн өөр ажилд шилжих болсонтой холбогдуулан Гэнэнгийн Төмөрхуягийг Үнэт цаасны хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Үнэт цаасны хорооны дарга, зарим гишүүнийг томилох тухай

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Содномцэрэнгийн Гүндэнбалыг Үнэт цаасны хорооны даргаар, Бядрангийн Лхагвасүрэн, Донхимын Баясгалан нарыг

Үнэт цаасны хорооны гишүүнээр тус тус томилсугай.

2. Энэ тогтоолыг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

### Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг 2000 оны 10 дугаар сарын 1-ний

ням гаригт явуулахаар 2000 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн товлон зарласугай.

2.Энэ тогтоолыг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

### Сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2000 оны

ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 300 сая 560 мянган төгрөгөөр тогтоосугай.

2.Дээрх зардлыг Засгийн газрын нөөцөөс гаргахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

### Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2.Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын 2000 оны батлагдсан орон тоо, төсвийг хэмнэх чиглэлээр шинэчлэн хянан баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай" Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

Улсын Их Хурлын 2000 оны 32 дугаар тогтоолын хавсралт

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын харьяанд	1. Тагнуулын ерөнхий газар 2. Төрийн өмчийн хороо	1. Радио, телевизийн Хэрэг эрхлэх газар 2. Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлаг
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд		3. Удирдлагын академи 4. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх ажлын хүрээнд	3. Үндэсний татварын ерөнхий газар 4. Улсын гаалийн ерөнхий газар 5. Санхүүгийн улсын хяналт, шалгалтын газар	
Гадаад хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд		5. Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд	6. Цагдаагийн ерөнхий газар 7. Хилийн цэргийг удирдах газар	6. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв 7. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар 8. Үндэсний архивын газар 9. Оюуны өмчийн газар 10. Гал түймэртэй тэмцэх газар 11. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар
Байгаль орчны сайдын эрхлэх ажлын хүрээнд	8. Байгаль орчныг хамгаалах алба	12. Ус, цаг уур, орчны шинжилгээний газар 13. Газрын Хэрэг эрхлэх газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх ажлын хүрээнд	9. Зэвсэгт хүчний ерөнхий штаб 10. Иргэний хамгаалалтын газар	
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх ажлын хүрээнд	11. Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын алба	



Дэд бүтцийн сайдын эрхлэх ажлын хүрээнд	12.Дэд бүтцийн улсын хяналтын алба	14.Эрчим хүчний удирдах газар 15.Нүүрсний газар 16.Иргэний нисэхийн ерөнхий газар 17.Шуудан, цахилгаан холбооны газар 18.Аялал жуулчлалын газар 19.Авто замын газар 20.Авто тээврийн газар 21.Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар 22.Төмөр замын Хэрэг эрхлэх газар
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх ажлын хүрээнд	13.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын алба	23.Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар 24.Хөдөлмөр зохицуулалтын газар 25.Улсын нийгмийн халамжийн газар
Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх ажлын хүрээнд	14.Үйлдвэр, худалдааны улсын хяналтын алба 15.Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв	26.Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар 27.Газрын тосны Хэрэг эрхлэх газар 28.Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар
Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх ажлын хүрээнд	16.Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба	29.Улсын нөөцийн газар 30.Улсын мал эмнэлгийн газар
Эрүүл мэндийн сайдын эрхлэх ажлын хүрээнд	17.Эрүүл мэндийн улсын хяналтын алба	

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

### Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ бү-

рийг Засгийн газрын гишүүдэд нэг бүрчлэн хариуцуулж ажиллахын хамт хөтөлбөрийн биелэлтийн явцыг Улсын Их Хуралд жил бүр танилцуулж байхыг Ерөнхий сайд Н.Энхбаярт үүрэг болгосугай.

ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ



Улсын Их Хурлын 2000 оны 33 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлын ээлжит гурав дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь 2000 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон МАХН-ын мөрийн хөтөлбөрт үндэслэн ирэх дөрвөн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилт нь:

-эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлэн гүнзгийрүүлж, өндөр өсөлтийг хангах;

-экспортын баримжаатай эдийн засгийн бодлого явуулж, тогтвортой өндөр өсөлтийг хангах;

-боловсрол, соёлыг дээдлэн хөгжлийн гол тулгуур - хүнээ хөгжүүлэх;

-нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг боловсронгуй болгон нийгмийн хамгааллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар амьдралын түвшинг дээшлүүлэх;

-бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлуулан хэрэгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, амьдралын түвшний зөрүүг багасгах;

-эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг Монгол орныхоо өвөрмөц онцлогт тохируулан боловсруулж үр дүнтэй хэрэгжүүлэх, өндөр чадавхитай, хариуцлагатай сайн засаглал тогтооход оршино.

### Нэг. НИЙГМИЙН БОДЛОГО

Нийгмийн салбарт баримтлах үндсэн зорилт нь хүний хөгжлийг хангах орчинг бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хуртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ.

1. Хүн амын боловсролын хэрэгцээг жигд хангах орчин бүрдүүлж бүх нийтээр суурь боловсрол эзэмших, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, орчин үеийн мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

-Боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

-Ачаалал ихтэй сургуулийн барилгыг өргөтгөх, шинээр барихын зэрэгцээ хөдөөгийн сургуулиудын барилгыг засварлаж, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангана.

-Боловсролын салбарт хувийн хэвшлээс хийх хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулна.

-Ерөнхий боловсролын сургуулиудыг компьютержүүлж, интернетийн сүлжээнд холбож эхэлнэ.

-Боловсролын агуулгыг хүүхэд, залуучуудыг ажигд сургах, амьдралд бэлтгэх, өөрийн орны уламжлалт болон

орчин үеийн үйлдвэрлэлийн үндэс суурийг эзэмшүүлэх чиглэлээр шинэчилж, орчны стандартыг батлан мөрдүүлж, чанарын үнэлгээний тогтолцоог төлөвшүүлнэ.

-Өөрийн орны болон гадаад орнуудын боловсролын баримт бичгийг харилцан зөвшөөрөх боломжийг идэвхтэй эрэлхийлнэ.

-Мэргэжлийн боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн журмыг шинэчлэн сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авна.

-Сурах бичгийг шинээр зохиох, хэвлүүлэх, түгээх арга механизмыг боловсронгуй болгоно.

-Дунд сургуульд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зардлыг төр хариуцдаг болно.

-Эмзэг бүлгийн болон олон хүүхэд нь зэрэг суралцдаг өрхийн 3-аас дээшхи хүүхдэд 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн хичээлийн хэрэгслийг үнэ төлбөргүй олгоно.

-Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, хүүхдийг цэцэрлэгт өргөнөөр хамруулахын зэрэгцээ гэрийн нөхцөлд хүүхдийг сургуульд бэлтгэх шинэ арга хэлбэрийг нэвтрүүлнэ.





-Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулийн салбарыг Монгол Улсад байгуулж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Эдгээр сургуульд суралцагсдад сургалтын төлбөрөө төлөхөд нь дэмжлэг үзүүлнэ.

-Дотоодын их сургууль, коллежид суралцдаг онц сурлагатай болон гоц авъяастай оюутнуудад урамшуулал, тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэнэ.

-Дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа ядуу өрхийн болон малчин өрх, хоёроос дээш хүүхэд нь зэрэг суралцаж байгаа айлын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцдаг болно.

-Дотоодын их сургууль, коллежид суралцагсдад үзүүлэх хөнгөлөлтийг олон улсын нийтлэг жишгийн дагуу бүрэн эдлүүлэх арга хэмжээ авч оюутнуудыг чөлөөт цагаараа хөдөлмөр эрхэлж амьдрал, ахуйгаа дээшлүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлнэ.

-Албан бус боловсрол, алсын зайны сургалт, түр хугацааны төрөлжсөн сургалтын хэлбэрийг оновчтой зохион байгуулж, сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол эзэмшүүлж, бичиг үсэг үл мэдэх явдлыг эрс бууруулна.

-Төрийн болон төсөвт байгууллагуудыг мэдлэг чадвар өндөртэй боловсон хүчнээр хангах нэгдсэн бодлого, хэрэгцээг тодорхойлж улсын захиалга өгч байх, захиалгын дагуу бэлтгэгдсэн гэрээт боловсон хүчнийг ажлын байраар хангах үүргийг төр хариуцна.

-Өндөр хөгжилтэй орнуудад сургах оюутан, магистрант, докторантын тоог нэмэгдүүлнэ. Орчин үеийн мэдээлэл, шинэ техник, технологитой танилцах гол хөшүүрэг болсон олон улсын түгээмэл гадаад хэл сургах, ашиглах өндөр шаардлага тавина.

-Багш, боловсролын удирдах ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчлэнэ.

-Тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг эрчимжүүлнэ.

**2.Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэж, хүн амыг эрүүлжүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилтыг хэрэгжүүлнэ.Энэ зорилтын хүрээнд:**

-Төсвөөс эрүүл мэндийн суурь тус-

ламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг жил бүр нэмэгдүүлнэ.

-Эрүүл мэндийн даатгалд хамрагдах эмчилгээ, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоох замаар төрийн өмчийн эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шинжилгээг үнэ төлбөргүй болгож, эрүүл мэндийн даатгалыг бие даалган хөгжүүлнэ.

-Эрүүл мэндийн суурь тусламжийг өрхийн эмнэлгээр үзүүлэх тогтолцоонд шилжүүлнэ.

-Дархлаажуулалтын сан байгуулж, тарилгаар урьдчилан сэргийлэгдэх халдварт өвчний тархалтыг шат дараалан бууруулах, улмаар устгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах өндөр настан, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, насанд хүрээгүй хүүхдүүд, тахир дутуу иргэдэд эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлнэ.

-Эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах, эндэгдлийг багасгах хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрөөс зардлыг нь санхүүжүүлнэ.

-Эмийн нэгдсэн бодлогын хүрээнд эм тарилгын хангамжийг сайжруулж, чанарын хяналтыг хүчтэй болгоно. Хэвтэн эмчлүүлэгсдийн эм тариа болон түргэн тусламжийн автомашины шатахууныг иргэдээс гаргуулдаг гажуудлыг арилгана.

"Эрүүл мэндийн технологи" үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

-Оношлогоо, эмчилгээний төвүүдийг эдийн засгийн бүсүүдэд байгуулж, орчин үеийн тоног төхөөрөмж, нарийн мэргэшлийн эмч мэргэжилтнээр хангана.

-Эмнэлгийн түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг сумдад 40-өөс доошгүй хувьд, аймаг, нийслэлд 60 хувьд хүргэнэ.

-Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг эмнэлгийн зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангах, эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, хөшүүргийг бий болгох замаар хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүртээмж, чанарыг сайжруулна.

-Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ялангуяа нөхөн сэргээх эмчилгээнд рашаан сувиллын үйлчилгээг өргөнөөр ашиглах зорилтыг хэрэгжүүлнэ.

-Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээг дэмжиж, тэдгээрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хүрээг өргөтгөнө.

-Эрүүл мэндийн байгууллага, эмч нарын магадлан итгэмжлэлийг чанаржуулан хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанарын баталгааг сайжруулна.

-Их спортыг төрийн ивээлд байлгана. Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, залуу үеийн бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор өргөн хөгжүүлнэ.

**3.Монгол Улсын үндэсний соёл, урлагийг дэлхийн соёлын нийтлэг ололт, үнэт зүйлс, дорнын соёлын өвөрмөц өнгө аястай уялдуулан эрчимтэй хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:**

-Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг төгөлдөржүүлж, удирдлагыг сайжруулна.

-Үндэсний уламжлалт соёл, урлагийг сонгодог болон орчин үеийн урлагтай хослуулан хөгжүүлнэ. Эх хэл, бичиг, соёлоо судлах, сурталчлах, эрхэмлэн дээдлэх, хүмүүсийн соёлтой харилцааны нийтлэг хэм хэмжээг төлөвшүүлнэ.

-Хархорум болон Монгол дахь Түрэгийн үеийн зэрэг зарим хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах төслийг хэрэгжүүлнэ.

-Сонгодог болон хүүхдэд зориулсан урлаг, ном хэвлэлийг төрийн ивээлд авч, тэдгээрийн уран бүтээлчдийг олон улсын уралдаан, тэмцээнд оролцуулах, мэргэжил дээшлүүлэхэд төрөөс үзүүлэх санхүүгийн тусламжийг нэмэгдүүлнэ.

-Сумдын соёлын төвүүд, номын сангийн үйл ажиллагааг сэргээж, хөдөөгийн хүн амын соёл, урлаг, мэдээллийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөтгөнө.

-Хүүхдийн номын ордон байгуулна.

-Урлаг, спортын гоц авъяастныг төрөөс хөхүүлэн дэмжинэ.

-Иргэдийн шүтлэг бишрэлийн чөлөөт байдлыг хангахын зэрэгцээ Монголын ард түмний соёл, мэдлэг, зан суртахууны өв болсон уламжлалт шашныг судлах, шашны урлагийг сэргээх, өвлөх, хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

-Монголчуудын оюун санааны амьдралд үндэсний эрхэм уламжлалыг дээдлэх, ахмад үеэ хүндлэх, өвөг дээдсийнхээ хүнлэг зан суртахууныг даган баримтлах үзэл сэтгэлгээ төлөвшүүлэхэд бүх шатны сургууль, соёл, шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ.

**4.Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадамжийг дээшлүүлэн хөгжлийн харьцангуй шинэ давуу тал олж авах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэмтэд, судлаачдын бүтээлийн үнэлэмжийг өсгөх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:**

-Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

-Хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан өөрийгөө санхүүжүүлдэг шинжлэх ухаан-боловсрол-үйлдвэрлэлийн бие даасан цогцолборыг байгуулан ажиллуулна.

-Уламжлалт технологи, биотехнологи, шинэ материал, мэдээллийн технологи, эрчим хүчний шинэ эх үүсвэр зэрэг судалгааны ажлын тэргүүлэх чиглэлээр өгөх улсын захиалгыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг дэмжин урамшуулна.

-Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр гадаад, дотоодод судлаач, эрдэмтэд бэлтгэх хэмжээг нэмэгдүүлнэ.

-Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бий болгож, эрдэм шинжилгээний номын сангуудын сан хөмрөгийг баяжуулан ашиглалтыг сайжруулна.

-Эрдэм шинжилгээний байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж, материалын хангамжийг нэмэгдүүлнэ.

-Шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохистой хослолыг бий болгон оюуны бүтээлийн үнэлэмжийг



дээшлүүлэн, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

-Олон улсын байгууллага, гадаад орнуудтай шинжлэх ухаан, технологийн салбарт идэвхтэй хамтран ажиллаж, хамтарсан лаборатори, төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

**5.Нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг оновчтой болгож, ард иргэдийн амьжиргааны түвшингийн уналтыг зогсоон, нийгмийн доторхи орлогын ялгааг багасгаж, туйлын ядуурлыг арилгах зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:**

-Өрхийн амьжиргаа доройтохоос урьдчилан сэргийлэх нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ядуу иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх үндсэн дээр амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн тоог 1999 оныхоос 2 дахин бууруулна.

-Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг энэ оноос эхлэн ээлж дараатай нэмэгдүүлэн 2000 оны эхэн үеийнхээс 3 дахин өндөр түвшинд хүргэнэ.

-Төсвийн байгууллагын ажилтны цалинг 2001 оноос эхлэн жил бүр нэмэгдүүлж, одоогийнхоос 2 дахин өсгөнө.

-Төрийн ажилтны ажиллах, амьдрах нөхцөл, хангамжийг сайжруулж, хувьдаа орон сууц барихад нь туслах зорилгоор хөнгөлөлттэй зээлийн сан байгуулна.

-Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид, багш, эмч нарт тусгай нэмэгдэл олгодог болно.

-Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцоог боловсронгуй болгож, чадвархийг нь дээшлүүлнэ.

-Нийгмийн даатгалын харилцааг боловсронгуй болгож, үр хүүхэд, гэр бүл, төрөл саднаа даатгалд хамруулах замаар эрсдэлээс хамгаалах бололцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг ирэх жилээс эхлэн нэмэгдүүлж 2 дахин өсгөнө.

-Тэтгэврийн насанд хүрээгүй тэтгэвэр авагч иргэдийн нөхөн олговрыг тэтгэврийн доод хэмжээнд хүргэж нэмэгдүүлнэ.

-Тэтгэврийн даатгалын нэрийн дансыг бүрэн нэвтрүүлнэ.

-Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, шимтгэл, хураамжийг хугацаанд нь бүрэн төлөх харуцлагыг дээшлүүлж, нийгмийн даатгалын сангуудын өөрийгөө санхүүжүүлэх чадварыг дээшлүүлнэ.

-Хөдөлмөрийн тухай хуультай уялдуулан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудыг шинэчлэн мөрдүүлнэ.

-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэдийн тахир дутуугийн тэтгэвэр авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэл болон тэднийг асрах, сувилах, эмчлэх зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлөх журамд шилжинэ.

-Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулна.

-Залуу гэр бүлийг сууцтай болоход нь зориулан урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох журам тогтоож, хэрэгжүүлнэ. Байгууллагын мэдлийн орон сууцыг хувьчлах асуудлыг шийдвэрлүүлнэ.

-Ахмад дайчдад үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

-Ядуу болон тахир дутуу иргэд, олон хүүхэдтэй эхчүүдэд үзүүлэх нийгмийн халамжийг нэмэгдүүлнэ.

-Иргэдийг ажил эрхлэх бололцоогоор хангах цогцолбор арга хэмжээ авах замаар шинээр ажлын байр бий болгох санаачлагыг дэмжин урамшуулна. Жижиг зээлийн санхүүжилтийн аргыг өргөн нэвтрүүлнэ.

-Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй арга хэмжээнд оролцох боломжийг бүрдүүлнэ.

-Хараа хяналтгүй хүүхдүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг аль болох гэр бүлд нь төвлөрүүлж, тэдний орон гэртээ хүмүүжих нөхцөлийг нь бүрдүүлэхэд анхаарна.

-Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын чиглэл, үйл ажилла-



гаг боловсронгуй болгоно.

-Орон нутагт жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, тариалан, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тахиа шувуу, зөгий зэрэг аж ахуй эрхлэхийг дэмжих зээлийн сан байгуулна.

-Гадаадад ажиллаж байгаа иргэдийн

эрхийг хамгаалах, гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

-Хүн амын шилжих хөдөлгөөний талаар төрөөс баримтлах бодлогыг бус нутгийн хөгжилтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

## Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**Макро эдийн засгийн тогтворжилтыг бататган экспортын баримжаатай, хувийн хэвшилд тулгуурласан бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх үндсэн дээр эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангана.** Уул уурхай, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах түвшинг ахиулах, экспортын үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгнө.

Эдийн засгийн өсөлтийн хурдацыг нэмэгдүүлж 2004 он гэхэд жилийн 6 хувьд хүргэнэ. Энэ зорилгоор дараахь бодлогыг хэрэгжүүлнэ:

- макро эдийн засгийн тогтворжилтыг хангана;
- банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлнэ;
- өмч хувьчлалыг үргэлжлүүлж, үр ашгийг нь дээшлүүлнэ;
- үндэсний үйлдвэрлэлийг сэргээж, экспортыг дэмжинэ;
- дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлнэ.

### 1.Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах хүрээнд:

-Төгрөгийн бодит ханшийг тогтворжуулж, инфляцийг эдийн засаг, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг урамшуулах оновчтой түвшинд байлгана.

-Төсвийн алдагдлыг бууруулна.  
-Ажилгүйдлийг 50-иас доошгүй хувиар бууруулна.

-Гадаад худалдааг алдагдалгүй болгох зорилтыг хэрэгжүүлнэ.

-Далд эдийн засгийг арилгах эрх зүй, эдийн засгийн цогц арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлнэ.

-Статистикийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэж, албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгон мэдээллийн ил тод байдлыг хангана.

### Татварын талаар:

-Татварын баазыг өргөтгөн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр боловсронгуй болгож, татвар цуглуулах үйл ажиллагааг эрс сайжруулна. Татварын албыг бэхжүүлэх цогцолбор арга хэмжээ авна.

-Татвар ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, татварын өр барагдуулах удирдлагыг боловсронгуй болгож, эрх зүйн зохицуулалтыг чангатгана.

-Татвар, хураамжийн давхардлыг цэгцлэн нэг мөр болгож нийтэд ил тод мэдээлнэ. Татварын хөнгөлөлт, чөлөөлтийг багасгана.

-Бус нутгуудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийг урамшуулах гааль, татварын ялгавартай уян хатан бодлого хэрэгжүүлнэ. Аж ахуйн нэгжийн татварын ачааллыг 30 хүртэл хувиар бууруулна.

-Хөдөө орон нутагт согууруулах ундаа үйлдвэрлэх, худалдан борлуулахаас бусад чиглэлээр ажлын байр бий болгосон хөрөнгө оруулагчдыг тодорхой хугацаагаар орлогын албан татвараас хөнгөлнө.

-Бага орлоготой иргэдээс авах орлогын албан татварыг бууруулах дэд дараатай арга хэмжээ авна.

-Импортын барааны гаалийн татварыг дунджаар 10 хувиар тогтооно.

-Экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг үйлдвэрүүдэд тоног төхөөрөмж, түүхий эд, материал импортлоход нь татварын хөнгөлөлт үзүүлнэ.

-Гаалийн татвар ногдуулалт, хөнгөлөлт, чөлөөлтийн бүртгэл, татвар төлөлтийн талаархи мэдээллийг нийтэд ил тод болгоно.

### Төсвийн талаар:

-Төсвийн орлогын эх үүсвэрийг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

-Төсвийг дунд болон урт хугацааны макро эдийн засгийн бодлоготой уялдуулан төлөвлөж, төсвийн санхүүжилтийг боловсронгуй болгож, үр дүнгээр нь санхүүжүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.

-Төсвийн зарлага санхүүжилтийн норм, нормативын үндэслэлийг сайжруулна.

-Төрийн сангийн бэлэн мөнгөний удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлнэ.

-Алт, зэс, ноолуур, нефть зэрэг стратегийн гол бүтээгдэхүүний үнийн эрсдлээс хамгаалах механизмыг бий болгоно.

-Тусгай зориулалтын сангуудын эх үүсвэр, зарцуулалтыг тодорхой болгож, тэдгээрийн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, ил тод байдлыг хангана.

-Орон нутаг төсвөө бие даан бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авна.

## 2.Банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх хүрээнд:

-Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, арилжааны банкуудыг хувьчлах, удирдлагыг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар банкны эрүүл тогтолцоог бүрдүүлнэ.

-Арилжааны банкуудын олгосон зээлийг эргэж төлүүлэхэд зээлдэгч, зээл олгогчдын хариуцлагыг өндөржүүлэх эрх зүйн зохицуулалтыг чангатгана.

-Хөдөө аж ахуйн банкыг Хөгжлийн банк болгон бэхжүүлж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ.

-Банкны бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, даатгалын компаниудын хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг ашиглах боловсронгуй механизмыг бий болгохтой холбогдсон хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

-Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх,

дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих мөнгө, зээлийн уян хатан бодлого явуулна.

-Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлж, хүрээг нь нэмэгдүүлэн, мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

-Үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, хувь нийлүүлэгчид ногдол ашиг хуваарилах, олгох механизмыг боловсронгуй болгож, тэдний эрх ашгийг хамгаална.

-Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг нь олшруулна. Даатгалын хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч, нийтэд ил тод мэдээлнэ.

## 3.Хувьчлалыг үргэлжлүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх хүрээнд:

-Хувьчлалын гажуудлыг арилгаж, хуулийг чанд сахин хэрэгжүүлэх хариуцлагыг өндөржүүлнэ.

-Хувьчлагдсан аж ахуйн нэгжийн удирдлагыг сайжруулах, эцсийн үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарна.

-Аж ахуйн нэгжийг хувьчлахдаа хуулиар зөвшөөрөгдсөн олон аргуудаас оновчтой нь сонгон ашиглаж, хувьчлалыг эрчимжүүлнэ.

-Эдийн засгийн үр ашиг, үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагад нийцүүлэн үнэ цэнэ бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчилна.

-Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийж, төрийн болон төрийн өмчийн оролцоотой түлш, эрчим хүч, уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн төрийн өмчид ногдох хэсгийг үе шаттайгаар хувьчилна.

-Нийгмийн салбарын хувьчлалын эрх зүйн үндсийг бүрдүүлж, хувьчилна.

-Өмч хувьчлалаас орох орлогыг хөрөнгө оруулалтад зарцуулах зарчим баримтална.

## 4.Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, экспортыг дэмжих бодлогын хүрээнд:



**Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар:**

-Ноолуур" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын ноолууран бүтээгдэхүүний экспортыг өсгөж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

-Ноолуур, улаан буудай зэрэг стратегийн чухал түүхий эдийн нөөц бүрдүүлж, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж түүхий эдээ бэлтгэх, эргэлтийн хөрөнгө бүрдүүлэхэд нь зээл олгох зэргээр туслалцаа үзүүлнэ.

-Мал аж ахуйн гаралтай түүхий эд, ялангуяа мах, ноолуур болон хонь, тэмээний ноос, арьс, ширний боловсруулалтын түвшинг ахиулна.

-Ноос", "Арьс шир" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, угаасан ноос, боловсруулсан арьсны экспортыг нэмэгдүүлнэ. Хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөр, адууны дэл, сүүл, арьс, ширний бэлтгэлийн стандартыг шинэчилж, түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах замаар экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

-Мах" хөтөлбөрийг баталж, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

-Мал эмнэлэг, эрүүл ахуй, хорио цээрийн нөхцөлийн хэлэлцээр байгуулах замаар мах, ноос, арьс, ширэн бүтээгдэхүүн экспортлох илүү өргөн бололцоо бүрдүүлнэ.

-Аж ахуйн нэгжийн удирдлагын чадавхийг сайжруулах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанарыг сайжруулна.

-Үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоог төрөөс татвар, зээлийн бодлогоор дэмжиж, үйлдвэр, үйлчилгээний болон ажлын байрны өсөлтийг урамшуулна.

-Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур зэрэг газарт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдүүлж хэрэгжүүлэх алхам хийнэ.

-Зах зээлийн нөхцөлд нийцсэн мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, боловсруулах тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн бэлтгэлийн ажлыг бөөний худалдааны сүлжээтэй уялдуулан зохион байгуулна.

-Гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

-Гадаадын хөрөнгө оруулалтын шат дамжлагыг цөөрүүлж, хөнгөн шуурхай, ил тод болгон нэг цэгийн цогц шуурхай үйлчилгээг хөгжүүлнэ.

-Тусламжийн барааны борлуулалтаас орсон орлогыг үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх зорилгод ашиглах, түүний ашиглалтын тухай мэдээллийг ил тод болгон хяналтыг сайжруулна.

- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, шудрага бус өрсөлдөөнийг хориглох, монополийн эсрэг тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон хэрэгжүүлнэ.

**Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар:**

-Уул уурхайн үйлдвэрлэлээс олох экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

"Эрдэнэт" үйлдвэрт технологийн шинэчлэлт хийж, зэсийн баяжмалын боловсруулалтын түвшинг гүнзгийрүүлэн үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

-Катодын зэс үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлж жилд 10-15 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэнэ.

-Алт олборлолтыг одоогийн хэмжээнээс 1.5 дахин өсгөнө.

-Төмөртэйн овооны цайрын орд, Бороогийн алтны үндсэн орд, Тосон, Баянголын алтны шороон ордыг ашиглах уулын үйлдвэрийг ойрын жилүүдэд барьж байгуулах, ашиглалтад оруулах нөхцөл, бололцоог хангана.

-Таван толгойн коксжих нүүрсний орд газрыг ашиглах асуудлыг боловсруулж, сонирхогч гадаад орнуудад санал болгоно.

-Тавтын алт, Цагаан суваргын зэс, Асгатын мөнгөний ордыг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

-Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах эрх зүйн орчин, татвар, санхүүгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлнэ.





**Эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг бүрдүүлэх талаар:**

-Газрын тосны эрэл хайгуулын судалгаа болон олборлолтын үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

-Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны хэмжээг жил бүр тогтвортой өсгөн 2,5 дахин нэмэгдүүлнэ.

-Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:200000-ын масштабтай геологийн зураг зохиох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

-Ашигт малтмалын орд илрүүлэх хэтийн төлөв бүхий талбай болон хил орчмын нутаг дэвсгэрийн 50000 хавтгай дөрвөлжин км-ээс багагүй талбайд 1: 50000-ын масштабтай геологийн зураг, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэнэ.

-Хөрөнгө оруулалт, татварын таатай нөхцөл бүрдүүлэх замаар ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг хувийн хөрөнгөөр явуулахад дэмжлэг үзүүлнэ.

-Газарзүйн мэдээллийн сүлжээг түшиглэн олон улсын мэдээллийн технологид нийцсэн геологийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

**Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоох талаар:**

-Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, түүний тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад чиглэгдсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлнэ.

-Тариалангийн газрын эзэмшил, ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглаагүй тариалангийн талбайн төлбөрийг нэмэгдүүлж, уриншилсан талбайн болон газраа үр ашигтай ашиглан тогтвортой ургац авч байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн газрын төлбөрийг хөнгөлнө.

-Үр үйлдвэрлэх аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагуудыг дэмжих

замаар буудайн чанар сайтай үрээр дотоодын хэрэгцээг хангана.

-Усалгаатай талбайн ашиглалтыг нэмэгдүүлнэ.

-Бордоо үйлдвэрлэх үүсгэл санаачилгыг дэмжинэ.

-Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

-Газар тариалан эрхэлдэг иргэд, жижиг аж ахуйд техникээр үйлчлэх аж ахуйн нэгжүүд бий болохыг дэмжинэ.

-“Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

-“Цагаан хувьсгал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хот суурин газрын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулна.

-Хүнсний үйлдвэрлэлийн стандарт, чанарын хяналтын тогтолцоог төгөлдөржүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

**Аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгох талаар:**

-Үндэсний аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалт, удирдлагыг боловсронгуй болгоно.

-Улаанбаатар, Хархорин, Өмнөговь, Хөвсгөл зэрэг газарт аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.

-Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулна.

5.Дэд бүтцийг бүс нутгаар хөгжүүлнэ.

-Авто зам, замын байгууламжийг барьж байгуулах, засварлах, арчлан хамгаалахад хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр оролцуулж байнгын орлоготой болгоно.

## Гурав. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО

Эдийн засгийг нутаг дэвсгэрээр бүсчлэн хөгжүүлж, бүс нутагт дэд бүтэц бүрдүүлэх, хөдөөд чиглэсэн татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогыг хэрэгжүүлэх замаар иргэд тухайн нутагтаа суурьшин амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эрхзүйн зохицуулалтыг бий болгож бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийн харьцангуй жигд хөгжлийг хангах дэс дараатай арга хэмжээг авна.

-Бүс нутгуудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлтийг урамшуулах гааль, татварын ялгавартай бодлого хэрэгжүүлнэ.

-Бүс нутаг бүрт түүхий эд, бараа, хүнсний бүтээгдэхүүний бөөний худалдааны сүлжээ бий болгож, хөдөөгийн хөдөлмөрчид, малчдыг харьцангуй хямд үнэтэй, чанар сайтай хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангана.

-Малчин өрхийн болон фермерийн аж ахуйн эрх зүй, эдийн засгийн харилцааг хуулиар зохицуулж, хоршоо, фермерийн аж ахуй байгуулах замаар малчид хамтын хүчээр аж ахуй, амьдралаа өөд татах үүсгэл санаачлагыг дэмжинэ.

-Мал сүргийг төрийн хамгаалалтад байлгах тогтолцоог зах зээлийн нөхцөлд нийцүүлэн төгөлдөржүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ, бэлчээр усжуулалт, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд төрийн бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

-Мал сүргийг даатгалд хамруулна.

-Мал сүргийг байгалийн гамшгаас хамгаалах тогтолцоо, гамшгийн тусламжийн сүлжээг бүрдүүлнэ. Бүс нутгуудад аймаг дундын отрын нөөц бэлчээрийг бий болгоно.

-1999-2000 оны зудын хохирлыг ойрын 2-3 жилд багтаан арилгах арга хэмжээ авна. Зудаар хохирол үзэж орлого нь амьжиргааны баталгаажих түвшинээс доош орсон малчин өрхийг малжуулах арга хэмжээг олон нийтийн хяналт, оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

-Малчин өрх, тариаланчид, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, үйлдвэрлэл-шинжлэх ухааны хоршиж ажиллах үүсгэл, санаачлагыг дэмжинэ.

-Малын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, хорио цээрийн эрх зүйн зохицуулалтыг зах зээлийн нөхцөлд тохируулан шинэчлэнэ.

-Малын бруцеллээ, ям, сүрьеэ, лейкоз, адууны цус багадах өвчинтэй тэмцэх ажлын чанарыг дээшлүүлж, мал эмнэлгийн лабораторийн оношлогоо, шинжилгээний чадавхийг сайжруулан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх чиглэлийг дэмжинэ.

-Хаягдсан, эвдэрсэн худгийг сэргээн засварлах, шинээр худаг гаргах замаар говь, тал хээрийн бүсийн бэлчээрийн 70-аас доошгүй хувийн усны хангамжийг сайжруулна.

-Уст цэгийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлэнэ.

-Аймгийн төвүүдийн нийтийн аж ахуй, усны хангамжийг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах цогцолбор арга хэмжээ авна. Хүн амын хэрэглээний эрдэсжилт, хатуулаг ихтэй усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

-Бүх аймгийн төв, сумдыг нийтийн халуун устай болгоно.

-Улаанбаатар, Ховд, Улаангом, Өлгий, Мөрөн, Улиастай хотуудын нийтийн аж ахуйг сэргээх ажлыг хэрэгжүүлж, төв болон зүүн 8 аймгийн төвийн нийтийн аж ахуйг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.

-Цахилгааны төвлөрсөн эх үүсвэрт 2 аймгийн төв, 40 гаруй сумын төвийг холбож, 80 гаруй сумын дизель станцыг шинэчилнэ.

-Сумын төвийн томоохон хэрэглэгчдийг сэргээгдэх эрчим хүчээр ээлж дараатай хангана.

-Хөдөөгийн малчин зуун мянган өрхийн нэн тэргүүний хэрэглээг нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангах арга хэмжээ авна.

-Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, замын аж ахуйг шинэчлэн сайжруулах, үер уснаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Бүс нутгийн болон эх газрын тээврийн сүлжээнд Монголын төмөр замын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

-Иргэний нисэхийн салбарт холбоо, навигацын шинэ техник, технологи нэвтрүүлсний үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх агаарын зайн ашиглалтыг нэмэгдүүлнэ.

-Иргэний нисэхийн зорчигч тээврийн онгоцны паркийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.



-Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзэлг хийх тогтолцоог олон улсын жишгийн дагуу боловсронгуй болгож шинэчилнэ.

-Олон улсын автотээврийн харилцааг өргөтгөн хөгжүүлнэ.

-Авто замын сүлжээний гол замуудын дагуух Булганы Эгийн гол, Завханы Тэс, Буянт, Сэлэнгийн Зүүнбүрэнгийн төмөр бетон гүүрүүдийг барьж ашиглалтад оруулж, Хэнтийн Хөмүүлт, Завханы Сархайрханы төмөр бетон гүүрийн барилгын ажлыг эхлүүлнэ.

-Бүх аймгийн төвийг мэдээлэл холбооны олон улсын болон дотоодын сүлжээнд холбогдох техникийн нөхцөлөөр хангаж, хот хоорондын холбооны автоматжуулалтын түвшинг 85 хувьд хүргэж, телефон хэрэглэгчдийн тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.

-Радио телевизийн студийн болон техникийн дамжуулах сүлжээг үндсэнд нь тоон технологиор өргөтгөн шинэчлэж, бүх аймгийн төвийг хэт богино долгионы FM-радио студитэй болгоно.

- Хөдөө орон нутагт хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийн сувгийн тоо болон цагийг нэмэгдүүлж, сонголын чанарыг сайжруулна.

-Шуудан холбооны үндсэн үйлчилгээний чанарыг сайжруулж шинэ үйлчилгээний төрлүүдийг нэвтрүүлж, багуудад хэвлэл, шуудаг хүргэх үйлчилгээг сайжруулна.

-Хөдөлгөөнт холбооны хамрах хүрээг өргөтгөнө. Мэдээллийн технологи, Интернетийг эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх хэрэгсэл болгон хөгжүүлнэ.

- Далай ашиглах тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх, далайн баялгийг ашиглах талаар чэрмайлт тавина.

-Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

-Нүүрсний уурхайнуудын техник технологийн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хөдөө орон нутгийн нүүрсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.

## Баруун бүсэд:

-Дөргөн, Улаанбоом, Үенчийн усан цахилгаан станцыг барих, баруун бүсийн эрчим хүчний системийг дотоодын эх үүсвэртэй болгох арга хэмжээ авна.

-Ховд, Өлгийн нисэх буудлыг шинэчлэн тохижуулна.

-Ховд-Улаангом-Хандгайт, Өлгий-Цагааннуурын авто замыг үргэлжүүлэн барьж, Арвайхээр-Баянхонгорын авто замыг Говь-Алтай-Ховд-Увс-Баян-өлгийн авто замтай холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ. Цэцэрлэг-Тосонцэнгэл-Улиастай, Ховдын Булган-Ярантын авто замыг барьж эхэлнэ.

-Баянхонгор, Говь-алтай, Ховд, Баян-өлгий, Увс, Завхан аймгуудын төвд сансрын холбооны ВиСАТ станцыг суурилуулах арга хэмжээ авна.

-Бүсийн радио релейн шугам, Завхан, Увс аймгийн төвийг холбосон дамжуулах байгууламжийг тоон технологид шилжүүлнэ.

## Хангайн бүсэд:

-Чаргайтын УЦС-ыг барьж, Эгийн голын усан цахилгаан станцыг барих эх үүсвэрийг идэвхийлэн эрэлхийлнэ. Баянтээгийн нүүрсний ордыг түшиглүүлэн дулааны цахилгаан станц барьж, Баянхонгор аймгийн төвийг эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбоно.

-Эрдэнэт-Булган-Мөрөнгийн чиглэлийн авто замыг барьж эхэлнэ. Хархорин-Цэцэрлэгийн авто замыг ашиглалтад оруулна.

-Архангай, Хөвсгөл аймгийн төвд АТС, кабель шугамын өргөтгөл, шинэтгэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

## Төвийн бүсэд:



-Даланзадгадын дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулна.

-Дархан-Эрдэнэт, Налайх-Мааньт-Чойрын хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна. Чойр-Сайншанд-Замын-Үүдийн авто замыг барьж эхэлнэ.

-Төв, Сэлэнгэ аймгийн сумдыг нэг цэгээс олон цэгт радио холбооны системээр холбоожуулах арга хэмжээ авна.

-Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн төвд сансрын холбооны ВисАТ станцыг суурилуулах арга хэмжээ авна.

### Зүүн бүсэд:

-Чойбалсангийн дулааны цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийг дуусган бүсийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж, хамрах хүрээг нь өргөтгөнө.

-Эрдэнэ сум-Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн авто замыг үргэлжлүүлэн барина.

-Чойбалсан, Баруун-уртын нисэх буудлыг шинэчлэн тохижуулна.

-Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн төвийг холбосон шилэн кабелийн сүлжээ

байгуулж, ойролцоох сум, суурин газрын холбооны тоног төхөөрөмжийг тоон технологиор өргөтгөн шинэчлэнэ.

### Нийслэлд:

-Улаанбаатар хотын цахилгаан, дулаан, усан хангамжийн системд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар хэрэглэгчдийг найдвартай хангана. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлж эхэлнэ.

-Орон сууц барих сан бүрдүүлж иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхийн хамт нийслэлд төрийн албан хаагчид, залуучуудад зориулсан 1000 айлын орон сууцны цогцолбор барина.

-Хотын замын сангийн хөрөнгөөр авто зам, гүүрийн шинэчлэлт, засварын ажил хийхээс гадна орон сууцны хорооллын доторх авто замыг иж бүрнээр засаж сайжруулах ажлыг гүйцэтгэнэ.

-Улс хоорондын станцыг өргөтгөнө.

-Гэр хорооллыг нэгдсэн бодлого схемийн дагуу хөгжүүлж, усан хангамж, холбоо, тээвэр, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулна. Газар эзэмших эрхийг баталгаажуулан тогтвор суурьшилтай байх нөхцөлийг хангаж, туслах аж ахуй эрхлэх боломж бүрдүүлнэ.

### Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Байгалийн баялгийг түүний даац, чадавхитай нь нийцүүлэн зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экологийн баримжаатай эдийн засгийн хөгжлийг хангах, орон нутгийнхаа байгалийн баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон иргэний эрх, үүргийг тодорхой болгож, байгаль орчныг ард иргэд өөрсдөө хамгаалах механизмыг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

-Тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байгаль орчны урт хугацааны бодлого, хөтөлбөрийг бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

-Байгаль орчны бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам, нутгийн захиргаад, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

-Байгаль орчинд халгүй дэвшилтэд технологи нэвтрүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хөхүүлэн дэмжинэ.

-Байгаль орчин, түүний гол нөөц, баялгийн экологи-эдийн засгийн болон хомсдлын өртгийн үнэлгээ, үзүүлэлтийг тогтоож, байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн стандартыг батлан мөрдүүлнэ.

-Байгалийн нөөц баялаг ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийг шинэчлэн тогтоож байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгоно.

-Ойн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлнэ. Ойн тухай үндэсний хөтөлбөрүүдийн эхний үе шатны зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

-Ашигт малтмалын ордыг байгальд халгүй технологиор ашиглах эрх зүй, хяналт, урамшууллын тогтолцоог бий болгоно.

-Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн, хамгаалалтын удирдлагыг сайжруулна. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн иргэдийн амьдрал, ахуйн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Ховор, нэн ховор амьтан, ургамалыг өсгөн үржүүлэх арга хэмжээ авна

-Байгаль орчны хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, ажлын үр дүнг сайжруулна. Ус, цаг уур, орчны болон бохирдол, цацрагийн хяналт-шинжилгээний тогтолцоо, техник, технологийг шинэчилнэ.

-Байгаль орчны мэдээллийн сангийн болон статистик мэдээллийн тогтолцоог олон улсын жишигт хургэнэ.

- Иргэдийн газар эзэмших, ашиглах эрхийг өргөтгөж, хэрэгжих нөхцөлийг баталгаажуулснаар эзэмшигчид газрын үржил шимийг удаан хугацаанд тогтвортой хүртэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно.

-Газрыг аж ахуйн эргэлтэд оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах чиглэлээр иргэд, байгууллагуудад удаан хугацаагаар баталгаатай эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

-Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, тэдгээрийн тогтвортой үйл ажиллагааг хангахаар газрыг урт хугацаагаар түрээслүүлэх хөшүүргийг боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

-Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цөл-

жилтийн явцын судалгааг олон улсын байгууллага, төслийн хүрээнд гүнзгийрүүлэн судалж цөлжилт, хөрсний эвдрэлтэй тэмцэнэ.

-Газрын хөрсийг эвдрэлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ургац нэмэгдүүлэх, хүн хүч хүрэх боломжгүй газар гарсан ой, хээрийн түймрийг унтраах зорилгоор тундас нэмэгдүүлэх, таримал ургамлыг мөндрөөс хамгаалах арга хэмжээ авна.

-Байгаль орчинд халгүй арга, технологийн бэлчээр, ойн хортон, хөнөөлт шавьж, мэрэгчидтэй тэмцэх, бэлчээрийн хорт ургамлын тархалтыг багасгах ажлыг эрчимжүүлж, үлийн цагаан огтонотой тэмцэх талбайг 2000 оныхоос 1,5 дахин нэмэгдүүлнэ.

-Улаанбаатар хотын хог хаягдлыг ялгах, тээвэрлэх, зайлуулах, байгаль орчинд халгүйгээр боловсруулах үйлдвэр байгуулж ашиглалтад оруулах асуудлыг цогцолборлоор шийдвэрлэнэ. Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон суурин газрын хог хаягдлыг ялгах, тээвэрлэх, зайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлын эхний ээлжийн бэлтгэлийг хангана.

-Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулах зорилгоор айл өрхийг бүрэн шаталттай, түлш бага хэрэглэдэг зуухаар дэс дараатай хангах ажлыг зохион байгуулна.

-Байгаль орчны хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Экологийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад орон, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

## Тав. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

1. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо, цэргийн шинэчлэлийн бодлогыг Төрийн цэргийн бодлогын үндсийн дагуу тууштай хэрэгжүүлж, энэ салбарт сүүлийн жилүүдэд гарсан гажуудал, бэрхшээлийг арилгах арга хэмжээ авна. Энэ зорилтын хүрээнд:

-Батлан хамгаалах тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаанд иргэний хяналт тавих арга, хэлбэрийг тусган мөрдүүлнэ.

-Зэвсэгт хүчин, хилийн цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэлийн тэргүүлэх чиглэлийг тогтоож эхний шатыг хэрэгжүүлнэ.

-Цэргийн байгуулалтыг боловсронгуй болгож, шинэчлэлийг гүнзгийрүүлж, цэргийн чадавхийг дээшлүүлнэ.

-Сайн дурын үндсэн дээр цэргийн албыг гэрээгээр хаах нөхцөлийг сайжруулж нэмэгдүүлэх замаар мэргэжлийн анги салбарын бие бүрэлдэхүүний мэргэшлийн түвшинг дээшлүүлнэ.

-Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн агуулгыг өнөөгийн зорилт, шаардлагатай нийцүүлэн өөрчилж боловсронгуй болгохын зэрэгцээгээр үндсэн үүргээсээ гадна байгалийн гамшиг, үйлдвэрийн ослын хор уршигийг арилгах, иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр сургаж дадлагажуулна.

-Цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг байгалийн гамшиг, үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх үйл ажиллагааны тодорхой чиглэлээр сургаж дадлагажуулна.

-Зэвсэгт хүчний алба хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг хангуулан хэрэгжүүлж эхэлнэ.

2. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт бие даасан байдлыг хамгаалах, иргэдийн амгалан тайван амьдрах орчныг бүрдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

-Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хууль



тогтоомж болон нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгоно. Хилийн цэргийн бие даасан тогтолцоог бий болгоно.

-Монгол Улсын хил дамнанасан хулгай таслан зогсоох чиглэлээр ажиллаж, ялангуяа Увс, Завхан, Хөвсгөл, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт хилийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, хилийн халдашгүй дархан байдлыг хангана.

-Хилийн цэргийн холбоо, техник хангамж, уналгыг үе шаттайгаар сайжруулна.

-Улсын хилийн хамгаалалтад орон нутгийн байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах тогтолцоог боловсронгуй болгоно.

-ОХУ, БНХАУ-тай байгуулсан хилийн дэглэмийн болон боомт, гарцын талаархи гэрээ хэлэлцээрийг боловсронгуй болгож шинэчлэх арга хэмжээ авна.

-Орон нутагт ажиллаж байгаа офицер, ахлагч нарын тогтвортой ажиллах сонирхлыг бий болгох арга хөшүүргийг бүрдүүлнэ.

-Офицер, ахлагч нарын ахуй хангамж, нийгмийн баталгааг сайжруулан тэдэнд энгийн мэргэжил давхар эзэмшихэд нь тусална. Хил дээр алба хааж байгаа офицер, ахлагч нарын гэр бүлийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.

-Бүс нутагт аюулгүй байдал, цэргийн итгэлцээлийг бэхжүүлэх олон талт арга хэмжээнд идэвхтэй оролцож, цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

-Байгалийн гамшиг, үйлдвэрийн томоохон ослын хор уршгийг арилгахад зориулсан хөрөнгө бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

-Үндэсний аюулгүй байдлын улс төр, эдийн засаг, соёл иргэншил, экологийн бүх талыг хангах, тэдгээрт сөрөг нөлөөлж болох гадаад дотоод хүчин зүйлсийг сэрэмжлэн зайлуулна.

-Иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж, иргэд цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

-Гадаадад ажиллаж байгаа өөрийн орны иргэд болон Монгол Улсад аж төрж байгаа гадаадын иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

**3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн**

**зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулна. Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх үйл ажиллагааг тууштай үргэлжлүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:**

### **Хөрш орнуудтай харилцах талаар:**

-Хөрш орнуудтай тогтоосон сайн хөршийн найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг уламжлал, итгэлцэлд тулгуурлан өргөтгөн хөгжүүлнэ.

-ОХУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээний заалт, үзэл санааны дагуу бүх салбар, чиглэлээр өргөтгөн хөгжүүлж, хуримтлагдсан асуудлуудыг зохистойгоор шийдвэрлэнэ.

-БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ болон 1998 оны хамтарсан мэдэгдлийн заалт, үзэл санааны дагуу тогтвортой хөгжүүлнэ.

-Хөрш орнуудын хил орчмын тулгамдсан асуудлуудыг зохицуулах болон эдийн засгийн хамтын ажиллагааны болромж, чадавхийг илүү ашиглах, үр өгөөжийг дээшлүүлэх, соёл, хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлнэ.

### **Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудтай харилцах талаар:**

-Ази-Номхон далайн бүс нутагт гадаад бодлогын идэвхтэй үйл ажиллагаа явуулж, тус бүс нутгийн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

-Монгол Улсын ардчилал, зах зээлийн тогтолцоог бэхжүүлэх, гадаад харилцааг өргөтгөхөд АНУ-тай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой гэж үзэж, харилцаа хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэх чиглэлээр ажиллана.

-Японтой тогтоосон иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид бататгаж өргөтгөн хөгжүүлнэ.

-Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

-АСЕАН-ы гишүүн орнууд, Австрали, Шинэ Зеланд, Канадтай тогтоосон улс төрийн харилцааны түвшинг ахиулж, хамтын ажиллагааны цар хүрээг өргөтгөн бэхжүүлнэ.

-Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс зэрэг Төв Азийн орнуудтай түүх, соёлын уламжлалыг эрхэмлэн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.



-Латин Америкийн орнуудтай олон улсын байгууллагуудын хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ, тус бүсийн нөлөө бүхий улс орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлээр ажиллана.

-Ази-Номхон далайн бүс нутаг, Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаар хоёр талын шугамаар санал солилцох, яриа хэлэлцээ идэвхтэй хийх ажлыг тогтмолжуулна.

## Европын орнуудтай харилцах талаар:

-Монгол Улсад ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бэхжүүлэх зорилтыг хангахад Европын орнуудтай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой гэж үзэж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

-Европын Холбоотой түншийн харилцаагаа бэхжүүлэн түүний гишүүн орнууд, тухайлбал ХБНГУ, Их Британи, Франц, Италиг хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлнэ.

-Европын бусад оронтой харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

## Ойрхи Дорнод, Африкийн орнуудтай харилцах талаар:

-Монгол Улсын нээлттэй гадаад бодлогын хүрээнд Ойрхи Дорнод, Африкийн орнуудтай харилцаагаа өргөтгөж, ялангуяа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

## НҮБ, олон улсын бусад байгууллагатай харилцах талаар:

-НҮБ, түүний системийн болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тэдгээрийн хүч, боломжийг улс орны аюулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй ашиглахыг чармайн ажиллана.

-Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол, цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэн цөмийн зэвсэггүй статусаа олон улсын хэмжээнд хуульчлан баталгаажуулна.

-Эвсгэлд үл нэгдэх хөдөлгөөн, 77-гийн бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хөгжиж буй орнуудын нийтлэг зорилго болон өөрийн орны үндэсний эрх ашигт нийцсэн асуудлуудаар хамтран ажиллаж, Умард-Өмнөдийн хоорондын яриа хэлэлцээг урагшуулж, тохиролцоонд хүрэхэд тус дөхөм үзүүлнэ.

-Олон улсын байгууллагын өмнө болон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

-Хүний эрх, байгаль орчныг хамгаалах, нийгмийн эмзэг бүлгийнхний байдлыг сайжруулах, үндэстэн дамнан асуудлууд, тухайлбал зохион байгуулалттай гэмт хэрэг, алан хядах үйл ажиллагаа, мансууруулах бодистой тэмцэхэд чиглэсэн олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэх боломжийг судалж, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

## Олон талт үйл явцад оролцох талаар:

-Ази-Номхон далайн бүс нутаг, Зүүн хойд Ази, Төв Азийн аюулгүй байдлын асуудлаарх олон талт үйл явц, яриа хэлэлцээ, бүс нутгийн эдийн засаг, улс төрийн интеграцид үр ашгтай оролцох оновчтой хэлбэрийг сонгож ажиллана.

-АСЕАН-ы Бүсийн чуулга /АФФ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, АПЕК, Ази-Европын улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт яриа хэлэлцээнд оролцоно.

## Гадаад эдийн засгийн харилцааг дэмжих чиглэлээр:

-Монгол Улсын гадаад улс төр, эдийн засгийн бодлогын нэгдмэл байдлыг хангаж, гадаад эдийн засгийн харилцааг улс орныхоо нийгэм, эдийн засгийн тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх бодлого баримтална.

-Хандивлагч орнуудтай нягт хамтран ажиллаж, гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг хангах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх таатай орчин бүрдүүлнэ. Энэхүү зорилгын үүднээс холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

## Монгол Улсын иргэдийн эрх ашгийг гадаад орнуудад хамгаалах чиглэлээр:

-Монгол Улсын иргэд гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, хилийн чанадад суралцах, хөдөлмөр эрхлэх нөхцөлд хууль эрхзүйн аль болох таатай орчин бүрдүүлэхийг чухалчилж, консулын үйлчилгээг олон улсын жишигт хүргэнэ.

## Соёл, хүмүүнлэгийн харилцааны чиглэлээр:

-Гадаад орнуудтай хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлэхдээ иргэд, төрийн бус байгууллагууд, орон нутгийн захиргаатай нягт хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих асуудлыг анхаарна.

-Боловсрол, соёл, урлаг, спорт, мэдээллийн олон улсын байгууллага, сангуудтай идэвхтэй харилцаж, шаардлагатай гэрээнд нэгдэн орж, хүмүүнлэгийн олон улсын арга хэмжээнд Монгол Улсын оролцоог идэвхжүүлнэ.

-Монголын үндэсний соёлыг сурталчлах замаар Монгол Улсыг сонирхогч, талархагчдын эгнээг өргөтгөх чиглэлээр ажиллана.

-Хилийн чанад дахь монгол гаралтай хүмүүстэй харилцаа, холбоогоо өргөтгөж,

хүч, бололцоог нь ашиглах, дэмжих бодлого явуулна.

## Зургаа. ЗАСАГЛАЛЫН ХЯМРАЛЫГ АРИЛГАХ, ДЭГ ЖУРМЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГО

**1.Төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, ард түмэндээ үр нөлөөтэй, шуурхай үйлчилж, тэдний үндсэн хэрэгцээг хангах, шударга ёсыг хэвшүүлэх, сайн засаглалыг бүрдүүлэхийг зорино. Энэ зорилтын хүрээнд:**

-Засгийн газар, яам, агентлаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.

-Засгийн газрын болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын эрх, үүргийн хуваарилалт, зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааны хэтийн төлөв, бүтцийг оновчтой болгож, ажил үүргийн давхардал, хүн амд үзүүлэх төрийн үйлчилгээний хийгдэгллийг арилгана.

-Төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлж, төрийн албаны ажилтны мэдлэг чадварыг ахиулж, төрийн байгууллагын чадвархийг дээшлүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

-Төрийн захиргааны байгууллагаас татвар, санхүү, нийгмийн даатгал, иргэний бүртгэл, эрүүл ахуй, газар эзэмших зөвшөөрөл олгох зэрэг хүн амд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, шуурхай байдлыг хангана.

-Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын эрх зүйн үндсийг боловсронгуй болгон шинэ тогтолцоонд орж, төрийн албыг оновчтой, зардал багатай ажиллах зохион байгуулалтанд шилжинэ.

-Хуулийн дагуу олгодог зөвшөөрлүүдийн давхардлыг арилгаж, холбогдох хууль тогтоомжийг батлан мөрдүүлэх замаар олгох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн тоог багасгах арга хэмжээ авна. Хууль бусаар зөвшөөрөл олгохыг зогсооно.

-Хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгож, энэ чиглэлээр төрийн бус байгууллагын оролцоог өргөжүүлж, албан бус сургалтыг дэмжинэ. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний эрх зүйн үндсийг тогтоож, орчин үеийн технологийн үндсэн дээр найдвартай шуурхай байдлыг нь хангах арга хэмжээ авна. Төрийн байгууллагуудын хооронд солилцох мэдээллийн стандартыг тогтоож мөрдүүлнэ.

-Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтыг боловсронгуй болгож мэдээллийн сүлжээ байгуулна.

-Иргэд өөрийн сонгосон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүнээс байгуулсан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд

хяналт тавих бололцоог өргөжүүлнэ.

- Төрийн бус байгууллагыг дэмжиж, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд болон ялангуяа нийгмийн салбарт оролцоог нь өргөжүүлнэ.

- Засаг даргын дэргэдэх зарим газар, хэлтэс, агентлагын орон нутаг дахь салбарыг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж Засаг даргад харьяалуулна.

-Засгийн газар, үйлдвэрчний байгууллага, ажил олгогчдын нэгдсэн холбооны гурван талт түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх болон төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулах үндсэн дээр төрийн зарим ажил, үйлчилгээг тэднээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.

-Хараа хяналтгүй хүүхэд, гэр оронгүй хүмүүс, архаг архичдын талаар тусгай бодлого боловсруулж, тэднийг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлж, цагдаагийн эргүүл, зохицуулалтын үйл ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгон уналга, техник хэрэгслэлийг шинэчилнэ.

-Хот, суурин газрын цагдаагийн эргүүл, жижүүрийн хуртээмж, шуурхай байдлыг сайжруулж иргэдийн амгалан тайван, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлж иргэд-цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

## 2. Төрийн албаны хариуцлагын тогтолцоог сайжруулан, нэр хүндийг өргөж, чадваржуулна.

-Төрийн ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх хэрэгцээг тодорхойлж, уг хэрэгцээг хангах санхүүжилтийн эх үүсвэр шаардахгүй сургалтын шинэ хэлбэрийг нэвтрүүлэхийн зэрэгцээ тэднийг дотоод, гадаадын дипломын дараахь сургалтад тодорхой бодлого, чиглэлтэйгээр хамруулж, төрийн албан хаагчдын мэргэшил, үр чадварыг дээшлүүлнэ.

-Улс төрийн бүх албан тушаалтан болон төр, засгийн өндөр албан тушаалд ажиллах хүмүүсийн өмч, орлогын бүртгэлийг сайжруулж, авилгалтай тэмцэх гэрээтэй ажиллуулна.

-Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, мэргэжлийн төрийн албан хаагчийн эрх ашгийг улс төрийн дарамт шахалтаас хамгаалах үр ашигтай механизм бүрдүүлж, бүх шатны төрийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, ажлын чиг үүргийг нарийвчлан тогтоож дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.

-Төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, төрийн албан хаагчийн ёс зүйн байдал тавих

хяналтыг чангатган үр нөлөөг нь дээшлүүлж, төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланд хөндлөнгүйн хяналт хийж баталгаажуулдаг журмыг хэвшүүлнэ.

-Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагаас иргэд, хэрэг-дэгчдийг дарамтлах, монополь байдлаа Буруугаар ашиглах аливаа илрэлтэй тэмцэх, энэ зорилгоор төрийн байгууллагаас иргэдийн тавьсан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хяналт тавих нийтийн гэрээний журамттай болгоно.

**3. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулна.**

-Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг судалж, хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тогтолцоог бий болгоно.

-Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг боловсронгуй болгоно.

-Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл шинэчлэх үндсэн чиглэлийг боловсруулан Улсын Их Хуралд оруулж батлуулана.

-Хүний эрхийн үндэсний байгууллага бий болгож, хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авна.

-Хууль, эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлыг хангана.

-Архианы сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албан хэрэг хөтөлтийг эмх цэгцтэй, боловсронгуй болгох арга хэмжээ авна.

-Оюуны өмчийн зохицуулалтыг дэлхийн жишигт нийцүүлэх ажлыг эрчим-

жуулж, оюуны өмчийн холбогдолтой хууль тогтоомжийг олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлнэ. Үндэсний болон уламжлалт оюуны бүтээл, технологийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

-Төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, үйлдэх холбоо, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.

**4. Авилгал, хээл хахууль, гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэж, тэдгээрийн бий болох хөрсийг арилгах зорилтыг хэрэгжүүлнэ.**

-Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

-Зэвсэгт дээрэм, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, борлуулах, мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэн гүйлгээнд оруулах зэрэг шинэ төрлийн онц ноцтой гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулна.

-Орлогын татвар, гаалийн үнэлгээ, татвар ногдуулалт, лиценз, зөвшөөрөл олгох зэргээр төрийн үйлчилгээ үзүүлсний төлөө шан харамж авах явдлыг таслан зогсооно.

-Хувьчлал, гааль, татвар, банк, мөрдөн байцаах үйл ажиллагаатай холбоотой бүдгэрч байгаа хэргүүдийг шалган тогтоож, үр дүнг иргэдэд ил тод мэдээлж байна.

-Шүүгчдийн сахилга, ёс зүйн байдалд олон нийтээс тавих хяналтын тогтолцоо бий болгож, шүүгчийг зүүлэн татах, огцруулах, тэдэнд хариуцлага хүлээлгэх механизмыг төлөвшүүлнэ.

-Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

2000 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их хурлаас ТОГТООХ нь:  
1. Улсын Их Хурлын 2000 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй.

1/ 2001 оны Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/ Монгол Улсын 2001 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл;

3/ Төрөөс 2001 онд баримтлах мөнгөний бодлогын тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/ Монголын Үндэсний радио, телевизийн тухай хуулийн төсөл;

5/ Монголын мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төсөл;

6/ Аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;

7/ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох болон нэн даруй устгах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцид нэгдэн орох тухай;

8/ Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах тухай хуулийн төсөл;

9/ Санхүүгийн хяналт, шалгалтын тухай хуулийн төсөл;

10/ Дипломат албаны тухай хуулийн төсөл;

11/ Төрийн ордны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

12/ Галт зэвсгийн тухай хуулийн төсөл;

13/ Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төсөл;

14/ Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төсөл;

15/ Авилгалын эсрэг хуулийн төсөл;

16/ Байгаль орчны төлөв байдлын тухай тайлан;

17/ Аюултай хог хаягдлыг зайлуулахад зөвшөөрөл олгох тухай хуулийн төсөл;

18/ Монгол улсын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

19/ Бусад.

2. Намрын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн Засгийн газраас санаачлах хуулиудын төслийг даруй өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н. Энхбаяр/-т даалгасугай.

3. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулиудын төслийг намрын чуулганаар хэлэлцэх бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Б. Энэбиш/-т даалгасугай.

**ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргах.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг эрхлэх газрын харьяа  
Хэлтэх үйлдвэрт хэвцэв.

☎ 327806  
320407